



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хотонт сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/113-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Утас: 703333019 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Албан шаардлага	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ХОТОНТ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА А.ОЮУНАА ТАНАА

2021.02.22 № 45
танай _____ -ны № _____ -Т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Хотонт сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	37,565,006.28	53,492,506.28
35	БАРАА МАТЕРИАЛ	37,565,006.28	38,492,506.28
35100	Түүхий эд материал	10,000,000.00	10,000,000.00
35110	Тусгай зориулалттай материал	10,000,000.00	10,000,000.00
35400	Хангамжийн материал	27,565,006.28	28,492,506.28
35410	Бичиг хэргийн материал	877,775.00	877,775.00
35420	Аж ахуйн материал	26,687,231.28	27,614,731.28
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	15,000,000.00
36300	Тэжээлийн нөөц	0.00	15,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,376,919,616.10	2,572,838,403.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,376,919,616.10	2,572,838,403.17
39200	Биет хөрөнгө	2,336,909,616.10	2,532,828,403.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,439,661,731.10	1,481,461,457.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-262,827,288.47	-239,252,053.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	273,306,545.00	214,016,545.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-113,587,793.45	-97,599,770.86
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	92,508,001.60	104,238,326.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-52,628,001.97	-55,787,140.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,916,308.00	39,916,308.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,770,194.32	-23,512,127.81
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,346,569,367.00	1,572,369,814.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-401,239,058.39	-463,022,955.66
39300	Биет бус хөрөнгө	40,010,000.00	40,010,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	40,010,000.00	40,010,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,414,484,622.38	2,626,330,909.45
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,414,484,622.38	2,626,330,909.45
51	Засгийн газрын хувь оролцоо	2,414,484,622.38	2,626,330,909.45
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	543,423,467.37	543,423,467.37
51200	Хуримтлагдсан үр дүн	997,803,925.77	1,209,650,212.84
51210	Өмнөх үеийн үр дүн	720,220,797.24	997,803,925.77
51220	Тайлант үеийн үр дүн	277,583,128.53	211,846,287.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	873,257,229.24	873,257,229.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,414,484,622.38	2,626,330,909.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	729,423,714.42	801,868,071.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	283,101,008.42	314,148,817.00
120	Нийтлэг татварын бус орлого	283,101,008.42	314,148,817.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	283,101,008.42	727,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	614,500.00	727,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	282,486,508.42	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	313,421,117.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	446,322,706.00	487,719,254.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,650,806.00	11,777,854.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,650,806.00	11,777,854.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	409,671,900.00	475,941,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	409,671,900.00	475,941,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	451,840,585.89	575,759,066.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	451,840,585.89	575,759,066.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	447,726,085.89	549,415,766.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	237,100,554.00	248,508,700.00
210101	Үндсэн цалин	237,100,554.00	248,508,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,028,046.00	33,548,800.00
210201	Тэтгэврийн даатгал	20,734,227.18	23,608,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,442,636.63	2,485,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,841,202.52	1,988,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	454,543.61	497,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,555,436.06	4,970,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,000,000.00	18,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	5,966,736.00	7,217,713.00
210302	Түлш, халаалт	10,033,264.00	10,782,287.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,654,110.00	35,877,350.00
210401	Бичиг хэрэг	8,576,000.00	5,420,500.00
210402	Тээвэр, шатахуун	26,133,810.00	20,389,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,200,000.00	2,200,000.00
210404	Ном, хэвлэл	700,300.00	211,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,044,000.00	7,655,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,226,050.00	4,308,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	
210604	Урсгал засвар	3,226,050.00	4,308,100.00
2107	Томилолт, зочны зардал	3,541,800.00	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	3,541,800.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,123,196.00	3,091,454.00

Архангай аймгийн Хотонт сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,873,196.00	1,191,454.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,100,000.00	1,100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	690,000.00	500,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	460,000.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,052,329.89	203,081,362.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,712,900.00	82,100,425.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	790,000.00	2,011,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,549,429.89	118,969,937.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,114,500.00	26,343,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000,000.00	22,115,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	17,615,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	4,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	114,500.00	4,227,700.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	114,500.00	4,227,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	277,583,128.53	226,109,004.84
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	14,262,717.77
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	14,262,717.77
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	277,583,128.53	211,846,287.07

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	543,423,467.37	873,257,229.24	720,220,797.24	2,136,901,493.85
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	543,423,467.37	873,257,229.24	720,220,797.24	2,136,901,493.85
4	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	277,583,128.53	277,583,128.53
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	543,423,467.37	873,257,229.24	997,803,925.77	2,414,484,622.38
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	543,423,467.37	873,257,229.24	997,803,925.77	2,414,484,622.38
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	543,423,467.37	873,257,229.24	997,803,925.77	2,414,484,622.38
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	211,846,287.07	211,846,287.07
10	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	543,423,467.37	873,257,229.24	1,209,650,212.84	2,626,330,909.45

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	446,937,206.00	488,446,954.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	614,500.00	727,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	614,500.00	727,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	614,500.00	727,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	614,500.00	727,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	446,322,706.00	487,719,254.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,650,806.00	11,777,854.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,650,806.00	11,777,854.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	409,671,900.00	475,941,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	409,671,900.00	475,941,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	420,937,206.00	472,716,629.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	420,937,206.00	472,716,629.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	416,822,706.00	446,373,329.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,355,600.00	248,508,700.00
210101	Үндсэн цалин	235,355,600.00	248,508,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,773,000.00	33,548,800.00
210201	Тэтгэврийн даатгал	22,358,800.00	23,608,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,353,600.00	2,485,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,882,800.00	1,988,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	470,700.00	497,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,707,100.00	4,970,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,000,000.00	18,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.00	7,217,713.00
210302	Түлш, халаалт	10,000,000.00	10,782,287.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,101,010.00	36,954,700.00
210401	Бичиг хэрэг	8,223,100.00	5,767,100.00
210402	Тээвэр, шатахуун	24,433,610.00	21,086,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,200,000.00	2,200,000.00
210404	Ном, хэвлэл	700,300.00	211,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,544,000.00	7,689,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,500,000.00	4,068,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	0.00
210604	Урсгал засвар	4,500,000.00	4,068,100.00
2107	Томилолт, зочны зардал	3,541,800.00	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	3,541,800.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,123,196.00	3,091,454.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,873,196.00	1,191,454.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,100,000.00	1,100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	690,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	460,000.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,428,100.00	99,201,575.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,928,100.00	96,369,675.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,500,000.00	2,831,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,114,500.00	26,343,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000,000.00	22,115,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	17,615,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	4,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	114,500.00	4,227,700.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	114,500.00	4,227,700.00

Архангай аймгийн Хотонт сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	26,000,000.00	15,730,325.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	26,000,000.00	15,730,325.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,000,000.00	15,730,325.00
2200	Дотоод эх үүсвэрээр	26,000,000.00	15,730,325.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,000,000.00	15,730,325.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-26,000,000.00	-15,730,325.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	476,441,400.00	472,441,400.00	4,000,000.00	99.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468,441,400.00	464,441,400.00	4,000,000.00	99.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	446,325,800.00	442,325,800.00	4,000,000.00	99.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,508,700.00	248,508,700.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	248,508,700.00	248,508,700.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,548,800.00	33,548,800.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	23,608,300.00	23,608,300.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,485,200.00	2,485,200.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,988,100.00	1,988,100.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	497,000.00	497,000.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,970,200.00	4,970,200.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,000,000.00	18,000,000.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	8,000,000.00	7,217,713.00	782,287.00	90.2
210302	Түлш, халаалт	10,000,000.00	10,782,287.00	-782,287.00	107.8
2104	Хангамж, бараа материалын зардал	36,868,300.00	36,868,300.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	5,723,100.00	5,767,100.00	-44,000.00	100.8
210402	Тээвэр, шатахуун	21,000,000.00	21,000,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,200,000.00	2,200,000.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	211,900.00	211,900.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,733,300.00	7,689,300.00	44,000.00	99.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,068,100.00	8,068,100.00	0.00	100.0
210602	Тавилга	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	4,068,100.00	4,068,100.00	0.00	100.0
2107	Томилот, зочны зардал	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилот	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,900,000.00	1,900,000.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,100,000.00	1,100,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,431,900.00	92,431,900.00	4,000,000.00	95.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	93,600,000.00	89,600,000.00	4,000,000.00	95.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,831,900.00	2,831,900.00	0.00	100.0

Архангай аймгийн Хотонт сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,115,600.00	22,115,600.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,115,600.00	22,115,600.00	0.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,615,600.00	17,615,600.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.0
222001	Тоног төхөөрөмж	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	476,441,400.00	472,441,400.00	4,000,000.00	99.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	475,941,400.00	471,713,700.00	4,227,700.00	99.1
320001	Орон нутгийн төсвөөс	475,941,400.00	471,713,700.00	4,227,700.00	99.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,000.00	727,700.00	-227,700.00	145.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	727,700.00	-227,700.00	145.5
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	53.00	53.00	0.00	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25	0	100.0
620001	Удирдах ажилтан	9	9	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	6	6	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,777,854.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,777,854.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,777,854.00
2104	Хангамж, бараа материалын зардал	86,400.00
210402	Тээвэр, шатахуун	86,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,191,454.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,191,454.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,777,854.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,777,854.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,777,854.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хотонт сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02/11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хотонт сумын ЗДТГ нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд зааснаар харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах чиг үүрэг бүхий аймаг, сумын ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлж, нутаг дэвсгэрийн баг, байгууллага, аж ахуй нэгж, үйлдвэрлэл үйлчилгээний салбаруудыг удирдамжаар хангаж, чиглүүлэх” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хотонт сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 476.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 211.8 сая төгрөгөөр буюу 8.8 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1.0	2.0	3=2-1	
Бараа материал	37.6	53.5	15.9	42.3
Үндсэн хөрөнгө	2,376.9	2,572.8	195.9	8.2
Нийт хөрөнгө	2,414.5	2,626.3	211.8	8.8
Өр төлбөр	-	-		
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,414.5	2,626.3	211.8	8.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,414.5	2,626.3	211.8	8.8

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл 42.3 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 37.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 63.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 47.6 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 53.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 8.2 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 2,376.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 15.7 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 313.4 сая төгрөг нийт 329.1 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгө акталны гарз 14.3 сая, тайлант хугацаанд байгуулсан 118.9 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр тус тус буурч, 2,572.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнг 211.8 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	409.7	475.9	66.2
Нэмэлт санхүүжилтийн орлого	36.6	11.8	(24.8)
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	282.5	313.4	30.9
Төсөв байгууллагын өөрийн орлого	0.6	0.7	0.1
Үйл ажиллагааны орлого	729.4	801.8	72.4
Цалин, шимтгэлийн зардал	267.1	282.0	14.9
Бусад бараа үйлчилгээний зардал	81.4	61.2	(20.2)
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7.1	3.1	(4.0)
Бараа үйлчилгээний бусад зардал	92.1	203.1	111.0
Урсгал шилжүүлэг	4.1	26.3	22.2
Үйл ажиллагааны зардал	451.8	575.7	123.9
Хөрөнгө акталсны гарз	-	14.3	14.3
Үйл ажиллагааны үр дүн	277.6	211.8	(65.8)

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оноос 66.2 сая төгрөгөөр буюу 16.2 хувиар буурсан байна. Харин үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оноос 10.9 хувиар өссөн нь Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлуудыг орлогод авч, бүртгэж тайлагнасантай холбоотой байна. Урсгал санхүүжилтээс 4.0 сая төгрөг хэмнэгдэж буцаан төвлөрүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 407.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг анх нийт 8.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 415.4 сая төгрөгөөр хянаж баталжээ. Харин төсвийн тодотголоор 61.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 476.4 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 476.4 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 475.9 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 0.7 сая төгрөг төвлөрүүлэн нийт 476.6 сая төгрөгийн орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 472.4 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 4.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь бараа үйлчилгээний бусад зардал 4.0 сая төгрөг хэмнэгдэж, төсөвт байгууллагын өөрийн орлого 0.2 сая төгрөгөөр давж биелсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтээр Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 1.2 сая төгрөг, аймгийн Засаг даргын гамшгаас хамгаалах зардлаас 10.0 сая төгрөг, АЗДТГ-аас цэрэг татлагын шатахууны зардалд 0.1 сая төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын зардалд аймгийн ИТХ-аас 0.3 сая төгрөг, Хүүхэд гэр, залуучуудын хөгжлийн газраас 0.2 сая төгрөг нийт 11.8 сая төгрөгийг тус тус хүлээн авч, тээвэр шатахууны зардалд 0.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 10.0 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 0.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллага нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 104.8 сая төгрөгийн өртөг бүхий өвс тэжээлийн агуулах, мөн 21.9 төгрөгийн өртөгтэй инженерийн хийцтэй худгийг үндсэн хөрөнгөнд бүртгэж, тайлагнасан байна.

Тус суманд хүчтэй аадар бороо орж, үер буусны улмаас орон нутгийн хайрган хучилттай зам, сумын төв доторх нийтийн эзэмшлийн зам тайлбай эвдэрч, гуу жалга үүссэн байна. Үүнтэй холбоотой нийтийн эзэмшлийн зам талбайг засаж сайжруулах зардлыг сумын Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс гаргасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 9 үндсэн зорилтын хүрээнд 66 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Сумын засаг даргаас 89.3 хувь гэж үнэлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 476.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 472.4 сая төгрөгийг зарцуулж, 99.2 хувийн биелэлттэй байна.

Тус байгууллага нь төсөвт байгууллагын өөрийн орлогоор 0.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 0.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаарх судалгааг авч үзэхэд:
 - Батлагдсан төсөвт зардлаас 4.0 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож, батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна.
 - Төсвийн хөрөнгөөр 4.0 сая төгрөгийн өртөг бүхий конторын тавилга худалдан авсан нь Монгол Улсын ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалттай нийцэхгүй байна.
 - Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн нь өндөр насны тэтгэвэр тогтоолгон чөлөөлөгдсөнд нөхөх томилгоо хийж, 5.9 сая төгрөгийн цалин олгосон нь зайлшгүй шаардлагатай албан тушаалын томилгоо байна.
 - Дотоод албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
2. Суудлын автомашин ашиглалтын судалгаа: Тус байгууллага нь нийт 86.3 сая төгрөгийн анхны өртөг бүхий 2 автомашинтай, шатахууны зардалд 13.4 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочийн цалинд 7.3 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хотонт сумын ЗДТГ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 145 мэдээллээс 106 мэдээллийг хугацаанд нь, 39 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуулинд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших зөвлөмжийг хүргүүлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

- Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан.Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 7.7 % буюу 13.7 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

- Төсвийн хөрөнгөөр 4.0 сая төгрөгийн өртөг бүхий конторын тавилга худалдан авсан нь Монгол Улсын ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4-т “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, ... хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй, 38.3 сая төгрөгийн элэгдлээ бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй үндсэн хөрөнгө бүртгэлтэй, 2.4 сая төгрөгийн сумын бусад төсөвт байгууллагуудад ашиглагдаж байгаа санхүүгийн программ бүртгэлтэй зэрэг зөрчлүүд илэрсэнд дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллах, элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн холбогдох арга хэмжээг авах, санхүүгийн программыг ашиглагч байгууллагад шилжүүлэх зэрэг 3 заалт бүхий зөвлөмж хүргүүлснийг 90 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудалгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 32.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

4.1 Албан шаардлага

- Гэрэл цахилгааны зардлаас төсөвт зохицуулалт хийлгүйгээр шинэ хорооллын айл өрхүүдийг гэрэл цахилгаанаар хангах ажлын хүрээнд 2.2 сая төгрөгөөр гэрлийн шонгийн бетон хөл худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.1-д “Төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах... төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх”, Сангийн сайдын 134-р тушаалаар батлагдсан " Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 4.1.1-д "Энэ

журмын 3.1-т заасан үндэслэлээр төсөвт зохицуулалт хийх саналаа ... тухайн шатны Засаг даргад тус тус бичгээр хүргүүлэн шийдвэрлүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль болон Сангийн Сайдын 134-р тушаалыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

- Засаг даргын нөөц хөрөнгийн 30.0 сая төгрөгийн зарцуулалт нь сумын Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэргүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн Сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 4.1-д "Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлыг шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн хууль болон Сангийн Сайдын 2021 оны 61-р тушаалыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хотонт сумын ЗДТГ	2	32.2	0	0	0	0	2	32.2	0	0
	Дүн	2	32.2	0	0	0	0	2	32.2	0	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Хотонт сумын ЗДТГ	3	17.7	0	0	0	0	2	17.7	1	0
	Дүн	3	17.7	0	0	0	0	2	17.7	1	0
	Нийт дүн	5	49.9	0	0	0	0	4	49.9	1	0